

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДААТГАЛЫН ГАЗАР

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2008 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА
ХОРООНЫ ГИШҮҮН
ХОРООНЫ ГИШҮҮН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д. БАЯРСАЙХАН
Б. ШАРАВСАМБУУ
Д. ДҮГЭРЖАВ
О. ГАНБАТ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

С. ГАНБОЛД
П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б. ОЮУНТУЯА

УЛААНБААТАР ХОТ
2008 ОН

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2008 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

2008 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, даатгалын зуучлагч 4 компани болон даатгалын төлөөлөгч 940 иргэн даатгалын зах зээлд оролцсон байна.

I. ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй дээрх 16 даатгалын компанийн хөрөнгийн нийт хэмжээ 35.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.8 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар, оны эцсээс 5.2 тэрбум төгрөгөөр буюу 17,4 хувиар өссөн байна.

2007 оны 3 дугаар улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 26.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 84.2 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15.8 хувийг эзэлж байсан бол 2008 оны 3 дугаар улиралд эргэлтийн хөрөнгө 30.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 86.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 пунктээр өссөнөөс харахад тайлант хугацаанд хөрөнгийн бүтцэд онцын өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2007-III		2008-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	22 105.9	84.2	30 308.9	86.6	8 203.0	137.1
Эргэлтийн бус хөрөнгө	4 140.1	15.8	4 728.0	13.4	587.9	114.2
Нийт хөрөнгө	26 246.0	100.0	35 036.9	100.0	8 790.9	133.5

2008 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 60.0 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 21.5 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 7.6 хувийг дансны авлага, үлдэх 10.9 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 6.2 дахин, түүний эзлэх хувь хэмжээ нь 16.8 пунктээр өсч хөрөнгийн бүтцэд нилээд өөрчлөлт гарсан нь өнгөрөгч 2007 оны 3 дугаар улиралд “Номин даатгал”, “Миг даатгал”, “Ганзам даатгал” ХХК-иуд богино хугацаат хөрөнгө оруулалт хийж байсан бол энэ оны 3 дугаар улиралд энэхүү 3 компаниас гадна “Прайм женерал даатгал”, “Монгол даатгал”, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд богино хугацааны хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна (Хүснэгт-2).

Эргэлтийн хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2007-III		2008-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16 733.0	75.7	18 170.8	60.0	1 437.8	108.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1 043.8	4.7	6 519.3	21.5	5 475.5	6.2 дахин
Дансны авлага	2 876.4	13.0	2 311.6	7.6	-564.8	80.4
Бусад эргэлтийн хөрөнгө	1 452.7	6.6	3 307.2	10.9	1 854.5	2.3 дахин
Эргэлтийн хөрөнгийн дүн	22 105.9	100.0	30 308.9	100.0	8 203.0	137.1

Энэ оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 12.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт даатгалын зах зээл дээрх хөрөнгийн 36.5 хувийг дангаараа эзэлж байсан бол “Нийслэл даатгал” ХХК хамгийн бага буюу 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.9 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 50 гаруй хувийг 3 даатгалын компани буюу “Монгол даатгал”, “Бодь даатгал”, “Миг даатгал” ХХК-иудын хөрөнгө бүрдүүлж байна.


Нийт хөрөнгийн хэмжээ

№	Компанийн нэр	Нийт хөрөнгө (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	12 775.3	36.5
2	Бодь даатгал	3 296.3	9.4
3	Миг даатгал	2 254.1	6.4
4	Прайм женерал даатгал	2 132.1	6.1
5	Номин даатгал	1 882.0	5.4
6	Ард даатгал	1 840.0	5.3
7	Түшиг даатгал	1 533.4	4.4
8	Практикал даатгал	1 466.0	4.2
9	Улаанбаатар хотын даатгал	1 272.6	3.6
10	Нэйшнл лайф даатгал	1 264.1	3.6
11	УБ даатгал	1 068.1	3.0
12	Мөнх даатгал	926.7	2.6
13	Монгол траст Холдинг даатгал	916.6	2.6
14	Ганзам даатгал	901.5	2.6
15	Жонон даатгал	859.5	2.5
16	Нийслэл даатгал	648.5	1.9
	ДҮН	35 036.9	100.0

II. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2008 оны 3 дугаар улиралд нөөц сангийн хэмжээ 21.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.4 тэрбум төгрөгөөр буюу 32.7 хувиар, 2008 оны эхтэй харьцуулахад 22.8 хувиар буюу 4.1 тэрбум төгрөгөөр өслөө. Нийт хөрөнгөнд өр төлбөр, эзэмшигчийн өмч болон нөөцийн сангийн эзлэх хувь хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд өр төлбөрийн эзлэх хувь буурч харин эзэмшигчийн өмчийн хувь хэмжээ бага зэрэг өссөн дүр зураг ажиглагдаж байна (Зураг-1).

Зураг-1



Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 556.2 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бол өнгөрсөн онд 807.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан байна.

III. ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант хугацаанд даатгалын салбар 17.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 4.2 тэрбум төгрөг буюу 23.5 хувийг давхар даатгалын хураамжид, 0.07 тэрбум төгрөг буюу 0.4 хувийг буцаасан даатгалын хураамжид олгож 13.6 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого олжээ.

Орлогод тооцсон хураамжийн 14.0 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан бүрдүүлэхэд, 29.0 хувийг нөхөн төлбөр олгоход зориулсан байна.

2007 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар даатгалын салбар 246.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол энэ оны 3 дугаар улирлын байдлаар 1.5 тэрбум төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажилласан нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 6 дахин өссөн байна. Хуримтлагдсан ашгийн хэмжээ ийнхүү огцом өссөн нь өмнөх оны мөн үед

алдагдалтай ажиллаж байсан даатгалын компаниуд, тухайлбал “Түшиг даатгал”, “Мөнх даатгал”, “Нийслэл даатгал” ХХК-иудын алдагдлын түвшин буурсан бол “Монгол даатгал”, “Практикал даатгал”, “Ганзам даатгал” ХХК-иуд энэ оны 3 дугаар улирлын байдлаар ашигтай ажилласан байна. Харин бусад даатгалын компаниудын ашиг өмнөх оны мөн үеийнхээс үлэмж хэмжээгээр нэмэгдсэн байна. Жишээлбэл: “Прайм женерал даатгал” ХХК-ийн ашиг 40,9 дахин, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн ашиг 20,9 дахин өссөн байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийг 2008 оны 3 дугаар улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 5.5 тэрбум төгрөг буюу нийт зах зээлийн 31.0 хувийг эзэлж хамгийн өндөр орлого олсон бол “Нэйшнл лайф даатгал” ХХК 8.9 сая төгрөгийн хураамжийн орлого олсон байна (Хүснэгт-4). Даатгалын зах зээл дэх нийт хураамжийн орлогын 55.2 хувийг “Монгол даатгал”, “Бодь даатгал” ХХК гэсэн ердөө 2 даатгалын компаниудын олсон хураамжийн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт-4


Даатгалын хураамжийн орлого
(сая төг)

№	Компанийн нэр	Хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Монгол даатгал	5 540.7	31.0
2	Бодь даатгал	4 334.5	24.2
3	Миг даатгал	1 700.3	9.5
4	Номин даатгал	1 244.2	7.0
5	Прайм женерал даатгал	1 021.5	5.7
6	Практикал даатгал	914.1	5.1
7	Түшиг даатгал	714.2	4.0
8	Мөнх даатгал	700.8	3.9
9	Ард даатгал	631.0	3.5
10	Улаанбаатар хотын даатгал	374.6	2.1
11	Жонон даатгал	266.0	1.5
12	УБ даатгал	130.8	0.7
13	Ганзам даатгал	122.3	0.7
14	Нийслэл даатгал	98.0	0.5
15	Монгол траст Холдинг даатгал	89.4	0.5
16	Нэйшнл лайф даатгал	8.9	0.1
	НИЙТ ДҮН	17 891.2	100.0

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

2008 оны 3 дугаар улиралд нийт 17.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 62.5 хувь буюу 11.2 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 25.0 хувь буюу 4.5 тэрбум төгрөг нь хариуцлагын даатгалын, 9.8 хувь буюу 1.8 тэрбум төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 2.8 хувь буюу 0.5 тэрбум төгрөг нь санхүүгийн даатгалын хураамжаас орсон орлого байна (Зураг-2). Санхүүгийн даатгалын хэлбэр бий болж зах зээлд нэвтэрснээр энэ хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нийт хураамжийн орлогод тодорхой хувь эзэлдэг болсныг эс тооцвол тайлант хугацаанд хураамжийн орлогын бүтэц өөрчлөгдсөнгүй.

Зураг-2



2008 оны 3 дугаар улирлын даатгалын хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын нийт хураамжийн орлого 4.2 тэрбум төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангиллаар нь задлан харвал амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 77.4 хувиар буюу 0.8 тэрбум төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал 29.1 хувиар буюу 2.5 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 18.7 хувиар буюу 0.7 тэрбум төгрөгөөр, санхүүгийн даатгалын хураамж 93.6 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-5).

Хүснэгт-5

Даатгалын хураамжийн орлого


(сая төг)

Даатгалын ангилал	2007-III		2008-III		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	987.5	7.2	1 751.4	9.8	763.9	177.4
Эд хөрөнгийн даатгал	8 649.4	63.3	11 170.6	62.5	2 521.2	129.1
Хариуцлагын даатгал	3 761.8	27.6	4 466.0	25.0	704.2	118.7

Санхүүгийн даатгал	255.3	1.9	494.2	2.8	238.9	193.6
Дүн	13 654.0	100.0	17 882.3	100.0	4 228.3	131.0

2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 3.4 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосны 71.0 хувь буюу 2.4 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 15.4 хувь буюу 0.5 тэрбум төгрөг нь хариуцлагын даатгалын, 9.3 хувь буюу 0.3 тэрбум төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 4.2 хувь буюу 0.1 тэрбум төгрөг нь санхүүгийн даатгалын нөхөн төлбөр байна (Зураг-3).

(Зураг-3)



Энэ оны 3 дугаар улирлын байдлаар олгосон нөхөн олговрын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт нөхөн олговрын хэмжээ 45.8 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангиллаар нь авч үзвэл амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын нөхөн олговор 1.1 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр буурсан бол эд хөрөнгийн даатгал 60.8 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 35.5 хувиар буюу 0.1 тэрбум төгрөгөөр, санхүүгийн даатгал 13.1 хувиар буюу 16.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

(сая төг)

Даатгалын ангилал	2007-III		2008-III		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	316.4	13.5	319.8	9.3	3.4	101.1

Эд хөрөнгийн даатгал	1 513.3	64.4	2 434.0	71.0	920.7	160.8
Хариуцлагын даатгал	392.7	16.7	528.1	15.4	135.4	134.5
Санхүүгийн даатгал	127.2	5.4	143.9	4.2	16.7	113.1
Дүн	2 349.6	100.0	3 425.9	100.0	1 076.3	145.8

V. НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2008 оны 3 дугаар улирлын байдлаар хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 19.2 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 2.0 пунктээр өссөн байна. Хохирол нөхөлтийн түвшинг даатгалын ангиллаар авч үзвэл амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 18.3 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.7 пунктээр, санхүүгийн даатгал 29.1 хувь болж 20.7 пунктээр буурсан бол эд хөрөнгийн даатгал 21.8 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.3 пунктээр, хариуцлагын даатгал 11.8 хувь болж 1.4 пунктээр тус тус өссөн байна (Хүснэгт-7). Тайлант хугацаанд хариуцлагын даатгалын хураамжийн орлого нь 93,6 хувиар өссөн бол үүний нөхөн төлбөр нь дөнгөж 13,1 хувиар өссөнөөс нөхөн олговрын түвшин ийнхүү огцом буурахад нөлөөлсөн байна. 2007 оны 3 улирлын байдлаар хариуцлагын даатгалын үйл ажиллагааг “Монгол даатгал” ХХК ганцаараа явуулж байсан бол энэ оны 3 дугаар улирлын байдлаар “Бодь даатгал”, “Прайм генерал даатгал”, “Практикал даатгал”, “Миг даатгал” ХХК-иуд энэ даатгалын хэлбэрийн үйл ажиллагааг шинээр явуулах болсноор хураамжийн орлого өссөн байна.

Хүснэгт-7

Даатгалын хураамж, нөхөн олговор, нөхөн олговрын түвшин, даатгалын ангиллаар

(сая төг)

Даатгалын ангилал	2007-III			2008-III		
	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	987.5	316.4	32.0%	1 751.4	319.8	18.3%
Эд хөрөнгийн даатгал	8 649.4	1 513.3	17.5%	11 170.6	2 434.0	21.8%
Хариуцлагын даатгал	3 761.8	392.7	10.4%	4 466.0	528.1	11.8%
Санхүүгийн даатгал	255.3	127.2	49.8%	494.2	143.9	29.1%
Дүн	13 654.0	2 349.6	17.2%	17 882.3	3 425.9	19.2%

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын нөхөн олговрын түвшинг харахад 2008 оны 3 дугаар улирлын байдлаар “Мөнх даатгал” ХХК-ийн нөхөн олговрын түвшин 59.5 хувьд хүрч хамгийн өндөр байгаа бол “Бодь даатгал” ХХК 5.7 хувьтайгаар хамгийн бага түвшинд байна (Хүснэгт-8).

Хүснэгт-8

Даатгалын хураамж, нөхөн олговор, нөхөн олговрын түвшин, даатгалын компаниудаар

(сая төг)

№	Даатгалын компанийн нэрс	2007-III			2008-III		
		Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин

1	Ард даатгал	723.5	147.2	20.3%	631.0	161.1	25.5%
2	Бодь даатгал	3 887.6	139.5	3.6%	4 334.5	248.7	5.7%
3	Ганзам даатгал	130.9	2.7	2.1%	122.3	7.4	6.1%
4	Жонон даатгал	203.2	12.1	6.0%	266.0	20.5	7.7%
5	Прайм женерал даатгал	841.8	93.4	11.1%	1 021.5	152.4	14.9%
6	Практикал даатгал	441.7	56.9	12.9%	914.1	70.6	7.7%
7	Миг даатгал	942.8	222.1	23.6%	1 700.3	246.6	14.5%
8	Монгол даатгал	4 494.9	1 233.5	27.4%	5 540.7	1 444.4	26.1%
9	Монголтраст холдинг даатгал	82.6	3.7	4.5%	89.4	16.8	18.8%
10	Мөнх даатгал	184.9	116.5	63.0%	700.8	416.7	59.5%
11	Нийслэл даатгал	90.7	5.8	6.4%	98.0	18.0	18.4%
12	Номин даатгал	793.2	218.6	27.6%	1 244.2	397.7	32.0%
13	Түшиг даатгал	373.2	47.2	12.6%	714.2	141.9	19.9%
14	УБ даатгал	112.0	21.7	19.4%	130.8	25.7	19.6%
15	Улаанбаатар хотын даатгал	351.1	28.7	8.2%	374.6	57.3	15.3%
ДҮН		13 654.0	2 349.6	17.2%	17 882.3	3 425.9	19.2%

19.2

VI. ДАВХАР ДААТГАЛ

2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 8 компани давхар даатгалд даатгуулж 4,2 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 171,9 сая төгрөгөөр буюу 4,3 хувиар, энэ оны эхний байдалтай харьцуулахад 1,8 тэрбум төгрөгөөр буюу 75,0 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төлсөн нийт давхар даатгалын хураамжийн 73.1 хувийг “Бодь даатгал” ХХК ганцаараа бүрдүүлж байгаа нь “МИАТ” ХХК-ийн иргэний агаарын хөлгийн даатгалыг хийсэнтэй холбоотой байна (Хүснэгт-9).

Хүснэгт-9

Давхар даатгалын хураамж

(сая төг)

№	Компанийн нэр	2007-III		2008-III		Өсөлт/бууралт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	86,5	2,1	17,7	0,4	-68,8	20,5

2	Бодь даатгал	3 005,0	74,6	3069,0	73,1	64,0	102,1
3	Прайм женерал даатгал	35,7	0,9	89,9	2,1	54,2	2,5 дахин
4	Практикал даатгал			9,1	0,2		
5	Миг даатгал	183,7	4,6	377,8	9,0	194,1	2,1 дахин
6	Монгол даатгал	713,0	17,7	574,6	13,7	-138,4	80,6
7	Номин даатгал	3,8	0,09	39,7	0,9	35,9	10,4 дахин
8	Түшиг даатгал			21,7	0,5		
	ДҮН	4 027,7	100.0	4 199,6	100.0	171,9	104,3

2007 оны 3 дугаар улиралтай харьцуулахад энэ оны 3 дугаар улирлын байдлаар “Номин даатгал” ХХК-ийн төлсөн давхар даатгалын хураамж хамгийн өндөр хувиар буюу 10,4 дахин өссөн нь өнгөрсөн онд зөвхөн “эрүүл мэндийн” хэлбэрийн давхар даатгалын хураамж төлсөн бол тайлант хугацаанд үүнээс гадна “байшин барилгын” хэлбэрийн давхар даатгалыг нэмж хийх болсонтой холбоотой байна.

VII. ДҮГНЭЛТ

2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар даатгалын салбарын тоон үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ерөнхийдөө даатгалын салбар нилээд өргөжин тэлж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал салбарын гол үзүүлэлт болох нийт хөрөнгийн хэмжээ 33.5 хувь буюу 8.8 тэрбум төгрөгөөр, эргэлтийн хөрөнгө 37.1 хувиар, эргэлтийн бус хөрөнгө 14.2 хувиар, нөөц сан 32.7 хувиар тус тус өссөн бол нийт өнгөрсөн онд салбарын хэмжээнд 807.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байсан бол энэ оны 3 дугаар улирлын байдлаар 556.2 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан байна.

Даатгалын бизнесийн үндсэн орлого болох даатгалын хураамжийн орлого ч мөн адил тайлант хугацаанд нилээд өндөр өсөлттэй буюу 31.0 хувьтай байсан бол нөхөн төлбөр 45.8 хувиар өсч нөхөн төлбөрийн өсөлтийн хурд даатгалын хураамжийн өсөлтийн хурдаас өндөр байсан байна. Даатгалын нөхөн олговрын түвшин энэ оны 3 дугаар улирлын байдлаар 19,2 хувь болж мөн л өмнөх оны мөн үеийн энэ үзүүлэлтээс 2,0 пунктээр өссөн байна.

Даатгалын компаниуд олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран ажиллах сонирхолтой болж эхэлж байгаа нь нилээд нааштай үзүүлэлт юм. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар давхар даатгалд төлсөн даатгалын хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,3 хувиар өссөн төдийгүй шинээр 2 даатгалын компани давхар даатгалын үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байна.

ДААТГАЛЫН ГАЗАР